



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 02 сарын 02 өдөр

Дугаар 66

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 4 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1, 4.10, 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Сэлэнгэ аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр бий болсон 10,000,000.00 (арван сая) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн харьяа Сэлэнгэ аймаг дахь Шүүхийн шинжилгээний албаны үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирал Б.Болдбаатар болон тогтоолд заасан байгууллагын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Худалдан авсан автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлэн авч хөрөнгө бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001448

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн
8.6 дугаар тогтоолын хавсралт

ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН ХАРЬЯА
СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АЛБАНД
БҮРТГЭХ ХӨРӨНГӨ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Хэм жих нэгж	Тоо шир хэг	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)
1	"Хьюндай соната-7, автомашин, 22-72 СЭН	ш	1	10,000,000.00	10,000,000.00
	Нийт дүн				10,000,000.00 (арван сая)